

Аудитын код: САГ-2018/121/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn



АГУУЛГА

1	Аудитын тайлан	1
1.1	Оршил.....	1
1.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
1.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
1.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
1.5	Дотоод хяналт	3
1.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
1.7	Шилэн дансны мэдээлэл	4
1.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
1.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
1.9.1	Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар.....	4
1.9.2	Үндсэн хөрөнгийн талаар	5
1.9.3	Зардлын талаар	6
1.9.4	Тайлангийн эхний үлдэгдлийн талаар.....	6
1.9.5	Авлагын талаар.....	6
1.9.6	Орлогын талаар	7
1.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
1.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
1.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
1.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
1.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	7
1.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
2	Менежментийн захидал	9
2.1	Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар	10
2.2	Зардлын талаар.....	11
2.3	Эхний үлдэгдлийн талаар.....	12
2.4	Авлагын талаар	13
2.5	Орлогын талаар.....	13
3	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
3.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
3.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
3.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
3.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
3.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19





**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2017.02.22 № 06/404
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ж.ГАН-ЭРДЭНЭ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, хязгаарлалттай санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Боловсролын үнэлгээний төвийн санхүүгийн тайланд



- 486,181.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тооллогод хамруулаагүй,
- 246,181.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглалтгүй байгаа ба түүнд 51,722.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан,
- 153,808.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн,
- ашиглаж буй үндсэн хөрөнгө, тооллогоорх бүртгэлээс 557.1 мянган төгрөгөөр дутуу,
- багшийн ажлын хөлсийг тогтоосон тушаал, шийдвэр байхгүй, байр хоолны, ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээн авсан акт, хүнсний материалуудын худалдан авалт, зарцуулалт тодорхой бус төсөвлөөгүйгээр 616,360.4 мянган төгрөгийг олгосон,
- сонгон шалгаруулалт, харьцуулалтын судалгаа хийлгүйгээр 173,937.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч бэлтгэсэн,
- санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 230,165.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- 1,929.1 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй,
- үндсэн үйл ажиллагааны орлогыг 2,397.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



1 АУДИТЫН ТАЙЛАН

1.1 ОРШИЛ

Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Боловсролын үнэлгээний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 5-наас 2018 оны 2 дугаар сарын 19-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Боловсролын үнэлгээний төвийн 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацааг нэг хоногоор хожимдуулан ирүүлсэн байна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Боловсролын үнэлгээний төв санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтыг үндэслэн Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар Боловсролын үнэлгээний төвийн дүрэм, бүтцийг 38 орон тоотойгоор баталсан байна.

Боловсролын үнэлгээний төвийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Засгийн газраас дэвшүүлэн хэрэгжүүлэхээр чиглүүлж буй “Гүйцэтгэлд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ”-ний арга зүй, зарчимд тулгуурлан хийх тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх;
- Бүх шатны боловсролын түвшин бүрт тохирсон үнэлгээний арга зүй, аргачлалыг боловсруулах;
- Боловсролын чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бий болгож, мөрдүүлэх;

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын талаар тавигдсан үндсэн чиглэлүүдийг хангахын тулд доорх зорилтуудын хүрээнд ажиллах болно. Үүнд:

- Улсын хэмжээнд бүх шатны боловсролын үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, боловсролын чанарын болон суралцагчдын мэдлэгийн түвшинд үнэлгээ хийх ажлыг төлөвлөн зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах, оролцогч талууд болон иргэд үйлчлүүлэгчдэд шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэх;
- Бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгаа хийж, боловсролын салбарын шинэчлэлд хөгжлийн бодлогыг боловсруулах, сургалт зохион байгуулах замаар хүний нөөцийн чадавхийг бүрдүүлэх, бэхжүүлэх;
- Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах анги төгсөгчдийн улсын шалгалт болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд элсэгчдийн суралцах чадвар, мэдлэгийн төвшинг тогтооход чиглэсэн улсын хэмжээний элсэлтийн нэгдсэн шалгалтыг зохион байгуулах;
- Боловсролын чанарын үнэлгээний болон суралцагчийн сурлагын амжилт, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнгийн мэдээлэл бүхий мэдээллийн сан бүрдүүлж оролцогч талууд болон иргэдэд үйлчилгээ үзүүлэх зэрэг болно.

Боловсролын үнэлгээний төвийн эрхэм зорилго нь Бүх шатны боловсролын стандартчлагдсан чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, энэ чиглэлээр хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө боловсруулж, бүх шатны боловсролын үйлчилгээнд үнэлгээ хийхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн үндэсний мэдээллийн нэгдсэн сан байгуулж иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэх зорилгын хүрээнд ажиллана.

Боловсролын үнэлгээний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 10 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Боловсролын үнэлгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Боловсролын үнэлгээний төв нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсролын үнэлгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын алба байхгүй, санхүү төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Боловсролын үнэлгээний төв 4 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 1,997,858.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,966,141.4 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь туслах үйл ажиллагааны орлого тасарсан, зарцуулах эрх нээгдээгүйн улмаас дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд туслах үйл ажиллагааны орлого 23,000.0 мянган төгрөгөөр тасарсан, улсын төсвийн санхүүжилт 14,481.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдэн, үндсэн үйл ажиллагааны орлого 5,763.8 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Үндсэн цалин 15,213.6 мянган төгрөг буюу 6.6 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 12,601.8 мянган төгрөг буюу 3.2 хувиар, томилолт, зочны зардал 5,131.2 мянган төгрөг буюу 45.0 хувиар, бараа, үйлчилгээний бусад зардал 4,328.4 мянган төгрөг буюу 0.4 хувиар, хангамж бараа материалын зардал 2,014.0 мянган төгрөг буюу 6.4 хувиар, байрны түрээсийн зардал 1,178.1 мянган төгрөг буюу 1.0 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 679.4 мянган төгрөг буюу 2.0 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Боловсролын үнэлгээний төв нь Шилэн дансны хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.eec.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. 5 сая төгрөгөөс доош үнийн дүн бүхий бараа, ажил үйлчилгээний тушаал, шийдвэрүүдийг оруулсан байна. Тендерээр худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, үнийн дүн, тендерт шалгарсан болон шалгараагүй байгууллагуудын нэр, байршил, холбогдох тушаал шийдвэрийн мэдээлэл болон худалдан авах ажиллагааны тайлан, жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна. Тайлант онд Нийцлийн аудитын газраас шилэн дансны шалгалт орж, шийдвэрийн хуулбар хавсаргаагүй байсан мэдээллийг нөхөж оруулсан.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 51 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.9.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар

Улсын бүртгэлийн гэрчилгээнд дараах өөрчлөлт, тэмдэглэл хийгдээгүй зөрчлүүд байна. Үүнд:

- ✓ БСШУСС-ын 2017 оны А/61 дугаар тушаалаар Боловсролын үнэлгээний төвийн дүрэм болон үндсэн үйл ажиллагааны чиглэлд орсон өөрчлөлт
- ✓ Захирлын томилгооны тэмдэглэл,
- ✓ Төрийн сан болон арилжааны банкин дах харилцах 8 дансны талаарх тэмдэглэл
- ✓ Улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн оноосон нэр, тус байгууллагын тамган дээрх нэр зөрүүтэй байна.



Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна”, 11.3-т “... 11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ”,

Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ”, 4.1.1-д “хуулийн этгээдийн оноосон нэр”, 4.1.5-д “гүйцэтгэх удирдлага”, 4.1.7-д “үйл ажиллагааны чиглэл”, 4.1.9-д “дүрэм, гэрээ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах, улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгөх;

1.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тус төвийн 2017 оны үндсэн хөрөнгийн бүртгэлд 938,450.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- ✓ Аймаг, нийслэлийн элсэлтийн ерөнхий шалгалтын төвүүдэд суурилуулсан хяналтын камер болон сонсгох төхөөрөмжийн систем зэрэг 486,181.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг 2016 оны 3 дугаар сард хийсэн эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ, шилжүүлгийн баримтыг үндэслэн бүртгэсэн ба жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогод хамруулаагүй,
- ✓ 2016 оны 10 дугаар сарын 5-ны өдөр орлогод авсан 170,000.0 мянган төгрөгийн хэвлэлийн машин, 2013 оны 12 дугаар сарын 27-ний өдөр орлогод авсан 9 нэр төрлийн 76,181.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 246,181.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр баглаа боодолтой ашиглалтгүй байгаа ба хэвлэлийн машинд 21,250.0 мянга, 9 нэр төрлийн тавилга, эд хогшилд 30,472.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсан,
- ✓ 2017 онд 109,998.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 43,810.0 мянган төгрөгийн програм хангамж нийт 153,808.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүйгээр худалдан авч бэлтгэсэн,
- ✓ Ажиллагчдын ашиглаж буй үндсэн хөрөнгө, тооллогын бүртгэлээс 557.1 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, ... ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон ... үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”,

”Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 1.2-т “... эд хөрөнгө ... акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа ... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”,

БСШУССайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.1.6-д “... үндсэн хөрөнгийн карт хөтөлнө, үндсэн хөрөнгийн ... тайланг улирал бүр гаргаж, ... тайланг гаргуулан хянаж,...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ”Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журам, БСШУССайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах, албан шаардлага өгөх;

1.9.3 Зардлын талаар

Элсэлтийн ерөнхий шалгалт болон боловсролын чанарын үнэлгээ, судалгааны ажлын хөлс, хоол, байрны зардалд 616,360.4 мянган төгрөгийг олгосон байна. Үүнд:

Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулахад ажлын хөлсөнд 404,202.3 мянга, хоол байранд 112,363.1 мянга, боловсролын чанарын үнэлгээ судалгааны ажлыг гүйцэтгэхэд ажлын хөлсөнд 99,795.0 мянган төгрөгийг олгосон нь сэдэв боловсруулах, хяналт шинжилгээ хийх, даалгаврын түлхүүрт эксперт хийх, сонсох даалгавар боловсруулах, бүртгэгч, хянагч, зохион байгуулагч, дүн оноо засалт зэрэг багшийн хөлсийг тогтоосон тушаал шийдвэр байхгүй, байр хоолны ажил гүйцэтгэх гэрээ, ажил хүлээн авсан акт, хүнсний материалуудын худалдан авалт, зарцуулалт тодорхой бус төсөвлөөгүйгээр олгосон,

Бичиг хэргийн материалд 61,574.1 мянга, байр хоолонд 112,363.1 мянган төгрөгийг зарцуулсан нь сонгон шалгаруулалт, харьцуулалтын судалгаа хийлгүйгээр бараа материалыг худалдан авч бэлтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлж, ажлын хөлсний цагийн үнэлгээ, байр хоолны зардлын хязгаарыг тогтоон, журам боловсруулан ажиллах зөвлөмж хүргүүлэх;

1.9.4 Тайлангийн эхний үлдэгдлийн талаар

2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдэл 230,165.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “... гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.9-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг ... үнэн, зөв мэдээллээр хангах ...”,

Аудитын олон улсын стандарт 510-д “Эхний аудитын гэрээт ажил – Эхний үлдэгдэл”-д “Эхний үлдэгдэл – Тайлангийн хугацааны эхэнд оршин буй дансны үлдэгдэл”, “Эхний үлдэгдэл нь өмнөх үеийн эцсийн үлдэгдэл дээр тулгуурлах ...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын олон улсын стандарт 510-ыг мөрдөж ажиллах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх талаар зөвлөмж хүргүүлэх,

1.9.5 Авлагын талаар

2017 оны жилийн эцсийн байдлаар авлага 5,777.7 мянган төгрөг ба 334 зувийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. 2013 онд үүссэн 1,929.1 мянган төгрөгийг барагдуулах ажил хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...”, 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулах, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар зөвлөмж хүргүүлэх;

1.9.6 Орлогын талаар

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 2,397.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орлогыг аккруэл сууриар бүртгэх, зөвлөмж хүргүүлэх;

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,653,738.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 690,497.4 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 938,450.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,024,790.3 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Боловсролын үнэлгээний төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 2 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Боловсролын үнэлгээний төвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,261,318.2 мянган төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 22,613.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

